

МОНГОЛЫН ДӨРВӨЛЖИН БОЛОН ТОД БИЧИГИЙН ДУРАСХАЛ ДАХИ
ШАШИНЫ БОДОЛГО ХИЙГЭЭД ХУУЛЬ ЦААЗЫН ТҮҮХЭНД ХОЛБОГДОХ
БАРИМТ СЭЛТЭЭС¹

Ц. Шагдарсүрэн*

0. Оршил

1. Дөрвөлжин бичигийн дурасхал дахи мэдээ баримт хийгээд тэдгээр нь шашины түүх болон хууль цаазын хэрэглэгдэхүүн болох нь
(*Нэмэлт-хавчуурга*)

2. Тод бичигийн дурасхал дахи мэдээ баримт хийгээд тэдгээр нь шашины түүх болон хууль цаазын хэрэглэгдэхүүн болох нь

3. *Нэмэх нь*: Монголчууд яагаад Бүддийн шашиныг сонгов?
Хавсралт 1, 2

0. Монгол түмний хэрэглэж ирсэн бичиг үсгээрхи монгол болон бусад хэлээр буй баримт дурасхалын гадаад дотоодод гарсан судлагааг авч үзхүл гол төлөв хэлний талаас нь авч үзсэн байх боловч агуулга буюу түүхийн баримт болох талаас нь анхаарч үзэж гэмээ нь Монголын гадаад харилцаа, нийгэм соёлын түүхийн хөдлөшгүй чухаг баримт болж өгдөг. Гэтэл ялангуяа түүхч, хуульч зэрэг манай судлагчидын тухайд тэдгээр баримт сэлтийг түүхэн судлагааны хэрэглэгдэхүүн болгосон зүйл бараг байхгүй ажээ. Наад зах нь: Монгол дөрвөлжин бичгийн дурасхал гэхэд монгол төрт Юан гүрний төрийн түүх, гадаад харилцааны бодолго, хууль цааз, шашин төрийн харилцааны албан ёсны хэрэглэгдэхүүн, тод бичгийн сурвалж гэхэд монголд шашин дэлгэрсэн түүхнээ шууд холбогдох хуульчилсан чухаг баримт сэлт болж өгөх боловч тэр мэт хэрэглэгдэхүүнийг монголын холбогдох холбогдох түүхийн судлагаанд хэрэгсэн үзсэн зүйл энэ хэр бараг алга байна. Энэ нь нэгэн талаас, тухайн судлагчийн гадаад болон эх хэл, түүнчилэн бичигийн сурвалжийн талаархи мэдэлгэ боловсрол хангалтгүй, нөгөө талаас, монгол хэл, эх бичиг, сурвалж судлалаар гадаад дотоодод гарсан олон бүтээлийг тэр бүр олж үзээгүйтэй, бас үзсэн ч ойшоон хэрэгсээгүйтэй давхар давхар

* Монгол Улсын Их Сургууль, Монгол судлалын төв

¹ Энэхүү өгүүлэлийг ХБНГУ-ын Эрдэм шинжилгээний солилцооны байгуулалга – ДААД (DAAD-Deutscher Akademischer Austausch Dienst)-ын дэмжилгээр Берлин хотноо цуглуулсан баримт хэрэглэгдэхүүнд тулгуурлаж бичсэн бөгөөд тус байгуулалгад гүнээ талархаж буйгаа илэрхийлэе.

холбоотой. Баримт гэдэг зүйл бол түүхийн хувьд ч, судлагчийн хувьд ч хамагийн чухаг зүйл бөгөөд баримтаас үүдэн судлагч зөв дүгнэж гэмээ нь түүх зөв болдог. Гэхдээ түүхэн сурвалжийг огт анхаардаггүй гэвэл бас даваадуулсан хэрэг болох боловч тэрхүү анхаарсан гэх зүйл нь ихэвчлэн хэн бүхэний мэддэг эл дол болсон ганц нэг баримтын нуруугий нь авч, бас “шинэ” баримт гаргаж гэмээ нь уг сурвалжаас нь бус, голдуу хөрвүүлж хялбарчилан өдгөөчилсэн хувилбараас нь эш авч, заримдаа бүр эсрэг утгаар нь ойлгон тайлбарлах, цаг хугацааг хагас мянганаар зөрүүлэх нь мэргэжилийн гэх түүхэчийн хувьд ч энгийн мэт зүйл болжээ. Ийм зүйл 1990-ээд оноос өмнө ч, хойно ч байсаар ирэв. 1990-ээд оноос өмнөхийг тухайн нийгмийн үзэл сурталаар тайлбарлан “цагаатгаж” болох талтай. Харин сүүлийн хориод жилд үзэл сурталын элдэв хаалт байхгүй болсон ч уг байдал улам өргөжсөөр байгаа нь нэгэн талаас хуучин эрчээрээ яваа багш нарын бэлтгэсэн дипломтан нарын боловсролын төвшинтэй, нөгөө талаас мэргэжилтэй биш сонирхогч нар “мэргэжилтэн” болж “хүний эрх”-ээ эдлэсэнтэй холбон тайлбарлуштай санагддаг.

Иймэд энэ удаад МУИС-ийн Эхбичиг судлах салбарын оюутнуудад зааж ирсэн лекцидээ үндэслэн зөвхөн шашины түүхэнд хамаарах буюу монгол дөрвөлжин бичгээрхи хаадын зарлигт буй олон шашныг үзэх үзэл хийгээд тод бичгийн сурвалжид буй монголд шашин дэлгэрэх үеийн бодот байдлыг тодруулах зарим баримт сэлтийг товч толилуулсу. Энэ нь тухайн үеийн цааз эрхимжийн нэгэн хэсэг мөний учир уламжлалт монгол хууль цаазын түүхнээ үнэт судлагдахуун болж өгөх нь эргэлзээгүй.

1. Монголын дөрвөлжин бичигээрхи зарлигт буй олон шашинтан хийгээд хууль цаазад холбогдох баримт сэлт:

Юан гүрний төрийн бичиг - монгол дөрвөлжин бичгээр бидний үед хүрэлцэн ирсэн Мангал (1276), Хубилай, Ананд, Өлзийтөөс аваад Тогоонтөмөр (1368) хааны зарлиг (үг, бичиг), хатаны (ижи), хааны багшийн (фа жи) хэмээх удаа дараагийн 40 шахам зарлигуудад² цөмд нь нэвт шувт хавсан нэгэн гол санаа буй нь Юан Улсын нутаг дэвсгэр дэхи бүддийн шашины *toyid*, несториан-христус шашины *erke'üd*, даогийн шашины *senšiniüd*, лалын шашины *dašmad* зэрэг³ олон санваартан хийгээд тэдний сүм хийдэд хэрхин хандах Их Монгол Улсаас уламжилаж ирсэн Юаны төрийн бодолготой шууд холбоотой.

Юан гүрэний хаан, хатан хийгээд хааны багшийн гаргасан (зарлиг, үг, бичиг, ижи, фа жи гэх зэрэг ялгаатай нэр бүхий) удаа дараагийн олон зарлиг нь цэрэгийн ноёд, цэрэг ард, балгад шилтгээний даргас, ноёд, зорчин явах элч нарт хандсан байх боловч гол агуулга нь дэлхийн соёлын дөрвөн гол хүрээ хэмээдэг дээр дурадсан дөрвөн гол шашины санваартан хийгээд

² Д. Төмөртоого, *Монгол дөрвөлжин үсэгийн дурасгалын судалгаа*, Улаанбаатар, 2002 [282 тал]; Ё. Жанчив, *Дөрвөлжин бичгийн монгол дурсгал*, - Monumenta Mongolica, Tomus III, Centre for Mongol Studies, Nat. University of Mongolia, Улаанбаатар, 2002 [195 тал].

³ Ed. Chavannes, *Inscriptions et pièces de Chancellerie chinoises de l'époque mongole*, - *T'oung pao*, - Serie II, Vol. VI, Leide, 1904, pp. 357-447; II partie, - *T'oung pao*, - Serie II, Vol. VI, Leide, 1905, pp. 1-42; Ed. Chavannes, *Inscriptions et pièces de Chancellerie chinoises de l'époque mongole*, (Second série) - *T'oung pao*, - Serie II, Vol. IX, Leide, 1908, pp. 297-428; Lewicki Marian, *Les inscriptions mongoles inédites en écriture carrée*, CO, No. 12, Wilno, 1937 [72 pp.] pp. 31-33.; N. Poppe, J. R. Krueger, *The Mongolian monuments in hPhags-pa script*, Göttinger AF, Band. 8, Wiesbaden, 1957 [147 pp.], pp. 82-83.

тэдний сүм хийдэд зориулан гаргасан, хэдийгээр *цан тамга* (газар болон худалдааны татвар⁴) үл авах хийгээд авах, мөн алба гувчуур, улаа шүүсээс чөлөөлөн бас бус эрх дарх олгосоноороо адил юм шиг боловч сайтар анхаарах бөгөөс дотороо багагүй учир ялгавартай. Үүнд:

Цаг хугацааны дараалалаар авч үзвэл аливаа шашинтаныг нэр заан эрх тэгш авч үзэх уламжлал Чингис хааны Их Монгол Улсаас үүдэлтэй байх бөгөөд үүнийг ч бараг зарлиг бүрт

.... Чингис ханы ба хааны зарлигт ... гэх буюу бүр дэлгэрүүлэн

.... Чингис ханы, Өгөөдэй хааны, Сэцэн хааны, Өлзийт хааны, Хүлэг хааны, Буянт хааны, Гэгээн хааны, Хутагт хланы, Ринченбал хааны ба хааны зарлигт ...

хэмээн тэмдэглэсэнээс харж болно. Ийнхүү олон шашин, олон шашинтаныг эрх тэгш үзсэн нь Их Монгол Улсын Төрийн гол бодолгын нэг байсан бөгөөд үүний дүнд улсын дотоодод төдийгүй, гадаад дахин дахи янз бүрийн шашин шүтэлгэ бүхий олон үндэстэний хувьд энх амгалангийн дуудалга болсоор ирсэн төдийгүй олон эрдэмтэний хүлээн зөвшөөрдөг *Pax Mongolica* буюу *Pax Mongolorum* хэмээх Монголын амгалан төр-ийн үндэс нь болсоор байж, уламаар Монгол төрт Юан гүрэний хувьд ч уламжилсаар байжээ. Өөрөөр хэлбэл Монгол Төрийн залгамж чанарын нэг тал нь энэ байсан ажгуу. Тухайлбал: энэ уламжлал Монгол нутагт, Хархорумд лавтайяа байсаныг Мөнх хааны монгол бичигээр үлдэж ирсэн 1254 оны зарлиг гэрчилэж өгнө⁵. Харин өдгөөгийн олон улсын харилцаанд шашин сурталын талаархи энэ бодолго аман уриа төдийхөн байгаа ч уг чанартаа дутагдаж байна уу гэж эрхгүй санагддаг.

Бас нэгэн зүйл: Юан гүрэний дөрвөлжин бичигээрхи эхин үеийн буюу 1276 оны Мангалын зарлигт

.... Чингис ханы ба... хааны зарлигт тойд. эрхүүд, сэншин дашмад *цан тамгаас бус аливаа алба гувчуур үл үзэн тэнгэрийг залбирч ерөөл өгөн атугай хэмээгдэгсэд ажгуу...* Эдүгээ-бээр бөгөөс урьдын зарлигийн ёсоор *цан тамгаас бусад аливаа алба гувчуур үл үзэн тэнгэрийг залбирч ерөөл өгөн атугай хэмээн ... барьж явах бичиг өгөв...*

хэмээн тэмдэглэсэнээс үзэхүл *цан тамга* буюу газар хийгээд худалдааны татвар авдаг байсан нь харагдана.

Харин Хубилай хааны зарлигаас үзэхэд:

...Эдний сүм хийдэд элчин бүү буутугай. Улаа шүүс бүү барьтугай. Цан тамга бүү өгтүгэй. Газар, ус, цэцэрлэг, тээрэм юу хээг нь булааж бүү автугай...

⁴ N. Poppe, J. R. Krueger, *The Mongolian monuments in hPhags-pa script*, Göttinger AF, Band. 8, Wiesbaden, 1957 [147 pp.], pp. 83-85, 121.

⁵ J. Nakamura, T. Matsukawa, *A Newly Discovered Inscription of Mongolian-Chinese Bilingual Edicts from Shao-lin si Temple* – Nairuku Asia Gengo no Kenkyu (Studies of the Inner Asian Languages), vol. VIII, Kobe, 1993, pp. [1-93 + 8 pl.], pp. 32-33; Dobu, Junast, *Textual Research and Explanation of an Inscription of Imperial Edicts both in Uighur Mongolian and hPhags-pa Scripts Unearthed at Shaolin Temple of Dengfeng Country, Henan Province*, - Minzu Yuwen, vol. 6, Beijing, 1993, pp. 59-64; Sergei, *Šoo lin se süm-e-yin kösiyen-ü mongyol bičig-un sudulul*, - Master čola qamγalaqu ögülel, Жолоодсон Ө. Мандах, *Öbür Mongyol-un Yeke Surγayuli, Kökeqota*, 1999, [78 tal-a]; Sergei, *Möngke qaγan-u üker jil-ün jarliy-un mongyol bičig-un šinjilege*, - *Öbür Mongyol-un Yeke Surγayuli, Erdem šinjilegen-ü bičig*, vol. 2, Kökeqota, 2001, 23-33 tal-a.; D. Tumurtogoo, with the Collaboration of G. Cecegdari, *Mongolian Monuments in Uighur-Mongolian Script (XIII-XIV centuries)*, Introduction, Transcription and Bibliography, Taipei, 2006, [722 pp.], pp. 10-11.

хэмээн түрүү авдаг байсан цан тамга хэмээх татвараас чөлөөлсөн нь харагдах бөгөөд дараа дараагийн зарлигт ч мөн ийн өгүүлжээ. Үүнээс үзэхэд Их Монгол Улсын үеэс уламжилал болсон улсын дотоод дахи олон шашинтаны талаархи бодолго нь Юан Улсын үед улам өргөжиж тэдгээр шашинтаны эрх хэмжээг түрүү түрүүчийнхээс нь илүү өргөтгөсөн гэж үзэх үндэс байна.

Зарлигуудаас үзвэл нэг талаас тэдгээр шашинтаныг цан тамга, алба гувчуур, улаа шүүс тэргүүтэнээс чөлөөлөн тэднийг “...бүү өгтүгэй...” хэмээсэн байх ба нөгөө талаас ноёд, харуулын ахлах нярав, даргач, цэрэгийн бүх ноёд, цэрэг ард (military personnel⁶), элч хэн боловч тэднээс цан тамга, алба гувчуур авч, улаа шүүс гаргуулах хийгээд адгуус мал хэд ч байсан булааж татаж авах, аяга сав юу хээг хүчээр болон гуйж авах, унаа малаа тэжээлгэх, ... гэх зэрэг хүч түрэмгийлэх бүхий л явдалыг хориглож “...бүү автугай... /...ёсгүй хүч бүү хүргэжтүгэй...” хэмээсэн нь зарлигт хамаарах хоёр талын этгээдийг тодорхойлон анхааруулсан хэрэг ажээ. Өөрөөр хэлбэл хууль ёсны үүднээс өртөгч буюу хохирогч болоод өртүүлэгч буюу хохироулагч нарыг тодлож өгсөн гэсэн үг.

Хэлшинжлэлийн үүднээс нэмэн тэмдэглэх хавчуурга: Энд буй *цэрэг ард* хэмээх хэлэлгийг одоогийн олонхи хүмүүс дараалан дурадсан хоёр нэр гэж ойлгож болох боловч монгол хэлний үүднээс *төмөр зам, шил аяга, сүрэл дээвэр, Цэцэг нуур, бүжигийн жүжиг* гэдэг жишигээр “*цэрэг(ийн) хүн*” гэсэн утгатай. Тэгээд ч Н. Поппе авгай англиар *military personnel* гэж орчуулсан хэрэг. Гадаад хүн ийнхүү зөв ойлгож, зөв орчуулж байхад өдгөө кирилл үсэгийн зөв бичихзүйн ташааралаас үүдэн сүүл үеийн ихэнхи хүмүүс монгол хэлнээ угтаа дэвсгэр гийгүүлэгчээр төгөссөн *цэрэг, шил, сүрэл, төмөр, цэцэг* гэх зэрэг олон нэр үг өгүүлбэрт тодотголын үүргээр орохдоо хэлбэрээ өөрчилдөггүй тэр хэвээрээ ордог, харин эгшигээр төгөссөн *хони, чоно, мори* зэрэг олон үг ардаа –*н* дагавар авч *хонин, чонон, морин* гэдэг хэлбэртэй болж тодотгох үүргээ гүйцэдхэдэгийг хэдийнээ ялгахаа больж бүх үгийг зөвхөн хоёдугаар жишигээр хэрэглэх болж, тэгээд “*монгол хүн юм чинь монгол хэлээ мэдэлгүй яах билээ*” гэж хоосон аархаж, “*хувхай байж авхай зантай*” гэгчээр буруугаа зөв гэж санадаг болсон нь монгол хэлийг мохоож байгаагаас биш хөгжүүлж байгаа хэрэг яав ч биш.

Зарлиг бүрт аливаа шашинтаны эрх хэмжээг ийнхүү өргөтгөхийн хажуугаар үүргийг нь анхааруулахаа мартсангүй. Өөрөөр хэлвэл энэ нь хуульзүйн үүднээс *эрх, үүргийн нэгдэл*-ийг хангажээ гэсэн үг. Одоогийн манай хууль тогтоогчидын эрхээ олж аваад үүргээ санаатай буюу санаагүй бүдгэрүүлдэг, мартдаг явдал тэр үед байгаагүй бололтой. Тийнхүү үүрэг болгож юу юу анхааруулсаныг тоймлон толилуулбал:

... эд (сэнишүүд / тойд /...) бас зарлигтан [=бичигтэн / =ижитэн / =фа житан^{11, 13}] хэмээж ёс үгүй үйлэс бүү үйлэдтүгэй. Үйлдвээс үл аюух уу?!

хэмээн эрх дархатай гэж цанхаалахгүй байхыг онцгойлон дурдаад тийм зүйл гарч гэмээ нь

⁶ N. Poppe, J. R. Krueger, *The Mongolian monuments in hPhags-pa script*, Göttinger AF, Band. 8, Wiesbaden, 1957 [147 pp.], p. 79.

бидэнээ очигтун гээд дараа нь гаднаас нь харахад асуусан мэт найруулга⁷ бүхий ерөнхий анхааруулга зарлиг бүрт буй.

Цааш нь тодруулан зүйлчилсэн, нэр заан тусхайлан хандсан олон хориг анхааруулга буй. Үүнд: эд юманд шунах, өөр зуураа тэмцэлдэх, эгэл ард лугаа маргалдан заргалдах, худал хэлэх, хулгай хийх, газар усаа худалдах болоод бэлэглэх тэргүүтэнийг хориглохын сац эвдэн сүйтгэсэн зүйл байх ахул “*сэлбэн засуулан автугай*” хэмээн зарлиг болгожухуй. Мөн ер энгийн ард, монгол болон төвөд иргэн, сэншин нарт нэр зааж

... (зарлигийг) *бус болгох ард үл айх уу?!*

...*Бэлэгчин, худалдаачин сэншинүүдийг эрүүтэн болготугай!*

гэх мэтээр тусхайлан анхааруулсан зүйл ч нэг бус буй. Энэ мэт баримт нь зарлигт санамсаргүй орсон зүйл огт бус, тухайлбал: монгол, төвөд иргэн гэж заасан нь тухайн ёсгүй үйлийг монгол, төвөд хүн нэг бус үйлэдсэн, сэншин нарын тухайд, өөр газар нүүн суурисах боломж бүхий нутагийн уугуул сэншин нар газар усаа бэлэглэх, худалдах зэргээр зарлиг зөрчисөн явдал нэлээд гардаг байсантай холбоотой нь мэдээж. Энэ мэтээр зарах, бэлэглэхийг хориглосон нь зарав, бэлэглэв хэмээх нэрээр элдэв ёсгүй үйлийг далдалах хэрэглүүр болж байсаныг гэрчилэж байгаа хэрэг. Ийнхүү татвараас зайласхийж хууль зөрчисөн зүйл газар, орон байр дээр одоо ч манайд байсаар байгаа зүйлийг тэр үеийн хууль цаазад тийнхүү сэргийлэн тусхасан ажээ.

Зарлигт ёсгүй үйл үйлэдсэн, элдэв зарга маргааныг хэн хэрхин шийтгэхийг ч тодорхой заажээ. Үүнд:

...*тойдын ёсоор үл явсан, муу үйлс үйлдсэн, худал хулгай хийсэн тойдыг балгадын даргад, ноёдод мэдүүлэгтүн... тэд нар тойдод мэдүүлэн эс чадвал дарга, ноёд гэж байхын хэрэг юун!*

Мөн үлэмж ноцтой хэрэг гарч гэмээ нь *бидэнээ очигтун* хэмээн онцлон заасан зүйл буйн дээр тэр цагийн өөр хууль журамын дотор

...*тойдууд харын* (буюу төрийн Ц. Ш.) *үйлд биднээ уригдаваас иртүгэй, эс уригдаваас бүү иртүгэй ...*

гэсэн үг тохиолддог нь тухайн үед сахил санваартан нарын эрх хэмжээг тодорхойлсон хэрэг буй заа.

Холбогдох шинэ баримтын талаар нэмэн тэмдэглэх хавчуурга: Бид энэ удаад монголын дөрвөлжин бичигээрхи Юан улсын удаа дараагийн хаан, хан хөвгүүн, хатан хийгээд хааны багшийн зарлигт буй баримтыг түшиж ярилаа. 2010 оны эхээр Нанжин Их сургуульд очих үед Юаны түүхийг судлагч профессор Төмөр ойрмог хэвлэгдсэн Шао-лин (Shao-lin) сүм хийдэд холбогдох чулуун дээрхи бичээсийн гурван боть цомогт буй нэгэн талдаа монгол хэл, монгол бичигээр гурав; монгол хэл, дөрвөлжин бичигээр нэг, нийт дөрвөн зарлигийг тус бүр хээгээр жаазлан давхарлаж

⁷ Энэ хэсэгийг профессор Н. Поппе (N. Poppe) нар *англиар* *Let them not perform illegal deeds, saying they are in possession of a writ [-edict^{ts} sh.]. If they do so, shall they not be afraid?* хэмээн үгчилэн орчуулсан боловч хоёрдугаар өгүүлбэрийг *...If they commit (them), they shall experience fright to the utmost...* гэж орчуулбал зохилтойг дурджээ: N. Poppe, J. R. Krueger, *The Mongolian monuments in hPhags-pa script*, Göttinger AF, Band. 8, Wiesbaden, 1957 [147 pp.], p. 90.

бичсэн, ардаа тус бүрийн үгчилсэн дөрвөн хэсэг хятад орчуулга бүхий чулууны бичээсийн нэн тодорхой дардасыг үзүүлж тусхайлан хуулбар хийлгэж өгсөн билээ⁸. Үүнээс үзэхүл тэдгээр дөрвөн зарлиг нь цөм өөр, тухайлбал: монгол бичигээрхи эхины зарлигийг үхэр жилийн өвөлийн эцэс сарын 7-нд дэлдсэн (!), хоёдугаархийг (монгол эхэд бичилгэ нь эргэлзээтэй тул хятад орчуулгаас нь тодруулбал) тахиа жилийн зуны эцэс сарын 1-нд, гутгаарыг луу жилийн хаварын тэргүүн сарын 25-нд, дөтгөөр буюу дөрвөлжин бичигээрхи зарлигийг хулгана жилийн хаварын эцэс сарын 13-нд тус тус бичсэн хэмээжүхүй. Дөрвөлжин бичигээр буй 32 мөр бичвэр нь Буянт хааны 1312 оны хавар гаргасан (энэ хэр бидний мэдэхээр) хоёрдахи зарлиг бөгөөд профессор J. Nakamura / T. Matsukawa (1993), Дов / Зуунаст (1994), Д. Төмөртоого (2002), Ё. Жанчив (2002), Ө. Хөгжилт (2004) зэрэг эрдэмтэний монгол хэлээрхи дөрвөлжин бичигийн дурасгалын судлагаанд багтсан нь буй⁹.

Монгол бичигээр буй гурван зарлиг нь агуулга болон бүтэцийн хувьд дээр өгүүлсэн дөрвөлжин бичигээрхи зарлигуудтай нэгэн адил. Гэвч тэр гуравтай яг тохирох дөрвөлжин бичигээрхи зарлиг үгүй. Монгол бичигээрхи гурван зарлигийг агуулгаас нь өнгөц авч үзвэл: гуравдахи зарлиг нь цаг хугацааны хувьд лавтай Юан Улсын эхин буюу Улсын багш Пагва ламын лагшин тунгалаг (1235 – 1279/1280) асан цаг үе, тухайлбал: түүний “багш”-ийн үйл ажиллагаатай лав холбоотой гэх үг өгүүлбэр буй тул нөгөө хоёр зарлиг нь түүнээс түрүү үед хамаарах буй заа. Үүний сац, монгол бичигээрхи зарлигийн агуулгыг дөрвөлжин бичигээрхи дараа дараагийн бусад зарлигтай харьцуулах бөгөөс багтаамжийн хувьд дөрвөлжин бичигийнхээс илүү дэлгэрэнгүй, тэнд байхгүй олон зүйл, наад зах нь дээр өгүүлсэнчилэн тойд тэргүүтэн лам нар “... эл (=зарлигтан^{Ц Ш}) хэмээж ёсгүй үйлэс үйлэдвээс ... Пагва багшид заатугай (=мэдэгдэтүгэй^{Ц Ш}). Пагва багш мэдтүгэй...” гэх зэрэг тодорхой заалт, тэргүүтэн байгаа нь шууд харагдах бөгөөд үүнээс үүдэж уг гуравдугаар зарлиг нь лавтайяа Хубилайн үеийнхи болох нь тодорч ирнэ. Бас эхиний зарлигт “...нэрийдэж уригдаваас иртүгэй, эс уригдаваас бүү иртүгэй...” хэмээн зарлиг хүртэсэн лам нарын эрх хэмжээг тодруулсан зүйл ч буй.

Нэгэнт ийм тул цаг хугацааны хувьд “сонгодог монгол бичигийн хэл” хэмээх болзомол үечилэлээс түрүү цагийн монгол бичигийн дурасгалыг судласан J. Nakamura

⁸ 中国少林寺 (Zhongguo Shaolin si), Vol. II, 中华书局 (Zhonghua Shuju), 2005年, pp. 84-85.

⁹ J. Nakamura, T. Matsukawa, *A Newly Discovered Inscription of Mongolian-Chinese Bilingual Edicts from Shao-lin si Temple* – Nairuku Asia Gengo no Kenkyu (Studies of the Inner Asian Languages), vol. VIII, Kobe, 1993, pp. 1-93; Д. Төмөртоого, *Монгол дөрвөлжин үсэгийн дурасгалын судалгаа*, Улаанбаатар, 2002, [182 тал], 21-23-р тал; Ё. Жанчив, *Дөрвөлжин бичгийн монгол дурсгал*, - Monumenta Mongolica, Tomus III, Centre for Mongol Studies, Nat. University of Mongolia, Улаанбаатар, 2002, [195 тал], 49-50-р тал; {Wu. Kögjiltü>}: 呼格吉勒图, 萨如拉, 八思巴字蒙古语文献汇编, 阿尔泰学丛书 (- A Series of Books for Altaic Studies,), 内蒙古教育出版社, 2004年, [537 pp], Photo § 09, pp. 89-100.

/Т. Matsukawa(1993)¹⁰, Дов/Зуунаст(1993, 1994)¹¹, Сэргэй(1999, 2001)¹², Д.Төмөртоогоо (2006)¹³ зэрэг эрдэмтэний бүтээлийг шүүрдэн үзвэл монгол бичигээрхи уг гурван зарлигийг цөм уншин судлаж Мөнх хааны 1254, Хубилай хааны 1261, 1268 оны зарлиг болохыг нь тодруулжээ. Үүнээс Сэргэй 1999 онд өгүүлэн буй монгол болон дөрвөлжин бичигээрхи дөрвөн зарлигийг хятад орчуулгынхи нь хамт судлаж Ө. Мандах профессорын удирдалгаар магистрын зэрэг хамгаалсан тул илүү дэлгэрэнгүй авч үзсэн байна. Харин дээрхи бүх судлагаанд хавсаргасан зарлигуудын гэрэл зураг нь төдий л тодорхой бус ажээ. Мөн доктор Ё. Жанчив *Сонгодог монгол бичгийн өмнөх үеийн дурсгалууд* (2006)¹⁴ хэмээх номынхоо жагсаалтад монгол бичигээрхи гурван захидалыг багтаан дуралдсан ажээ.

Энэ бүхэнээс үзвэл монгол бичигээрхи дээрхи гурван зарлиг нь дөрвөлжин бичиг зохиохоос өмнөхи үед хамаарах тул нэгэд, монгол бичигээр байгаагийн, хоёрт дөрвөлжин бичигээр байгаагүйн учир холбогдолыг тодорхойлж буй хэрэг.

Энэ бүхэн нь тухайн үед Юан улс даяар Улсын бичиг хэмээгдэж байсан дөрвөлжин бичигийг зохиохоос өмнө монгол бичигээр хятад (үгчилсэн) орчуулгын хамт зарлиг тархааж байсаны бодат баримт болж өгнө. Хятад орчуулгатай нь тулгаж үзэх бөгөөс нэгэн талаас, монгол эхэд буй зарим эргэлзээтэй зүйлийг тодруулах боломжтой боловч нөгөө талаас, орчуулгын найруулга нь үгчилсэн байдалтайн дээр арванхоёр жилийн нэр дээр дүйх уламжлалт ханз болон “*газарын эрхэтэн*”-ий ханзыг хольж тэмдэглэсэн зэрэг ялгаа зөрөө цөөнгүй байгааг товч тэмдэглэсү. (Гэрэл зурагийг 1-р хавсралтад толилуулав).

Энэхүү өгүүлэлд нэгэнт дөрвөлжин болон тод бичигээрхи шашин сурталтай холбогдох зарлиг - албан баримтыг онцлон авч үзэхийг зорьсон тул өгүүлэлийнхээ нэрд захируулан агуулгын хувьд холбогдож болох ч энэ удаа эл нэмэлт хавчуургаар хязгаарлаж дараа монгол бичигээрхи зарлигийн талаар тусхай судлагааг гаргах болно.

¹⁰ J. Nakamura, T. Matsukawa, *A Newly Discovered Inscription of Mongolian-Chinese Bilingual Edicts from Shao-lin si Temple* – Nairuku Asia Gengo no Kenkyu (Studies of the Inner Asian Languages), vol. VIII, Kobe, 1993, pp. [1-93 + 8 pl.:] 32-33, 34-37, 41-45.

¹¹ Dobu, Junast, *Textual Research and Explanation of an Inscription of Imperial Esicts both in Uighur Mongolian and hPags-pa Scripts Unearted at Shaolin Temple of Dengfeng Country, Henan Province*, - Minzu Yuwen, vol. 6, Beijing, 1993, pp. 59-64, 65-71 (хятад хэлээр); Dobu, Junast, *Textual Research and Explanation of an Inscription of Imperial Esicts both in Uighur Mongolian and hPags-pa Scripts Unearted at Shaolin Temple of Dengfeng Country, Henan Province, II. The Edict of Khubilai of the Year of Dragon*, - Minzu Yuwen, vol. 7, Beijing, 1994, pp. 32-37 (хятад хэлээр).

¹² Sergei, *Šoo lin se süm-e-yin kösiyen-ü mongyol bičig-un sudulul*, - Master čola qamγalaqu ögülel, Жолоодсон Ө. Мандах, *Öbür Mongyol-un Yeke Surγayuli, Kökeqota*, 1999, [78 tal-a]; Sergei, *Möngke qayan-u üker jil-iin jarliy-un mongyol bičig-un šinjilege*, - *Öbür Mongyol-un Yeke Surγayuli, Er Jem šinjilegen-ü bičig*, vol. 2, Kökeqota, 2001, 23-33 tal-a.

¹³ D. Tumurtogoo, with the Collaboration of G. Cecegdari, *Mongolian Monuments in Uighur-Mongolian Script (XIII-XIV centeries)*, Introduction, Transcription and Bibliography, Taipei, 2006, [722 pp.], pp.10-14.

¹⁴ Ё. Жанчив, *Сонгодог монгол бичгийн өмнөх үеийн дурсгалууд*, - Corpus Scriptorum (National University of Mongolia), Tomus II, Улаанбаатар, 2005, [240 тал], 19, 29-р тал

2. Тод бичигийн сурвалж дахи лам хуврага, сүм хийд болон хууль цаазад холбогдох баримт сэлт:

1978 онд америкийн нэрт монголч эрдэмтэн Ж. Р. Крюгер (John R. Krueger) “*Ойрод цааз, түүхийн шинэ хэрэглэгдэхүүн*”¹⁵ гэдэг өгүүлэлийнхээ Нэгдүгээр хэсэгт *Жинжилийн зарлиг*-ийн тод эхийг англи орчуулгынхи нь хамт оруулжээ. Энэхүү зарлиг нь 1640 оны Монгол, Ойродын цааз хуулийн нэмэлт болгон ойрод газар гаргасан 1678 оны Галдан хун тайж, 1741-1753 оны Дондугдаши ханы зарлигийн үргэлжлэл буюу 1822 оны Жинжилийн зарлиг бөлгөө. Зохиогч уг сурвалжийг А. М. Позднеевын “*Халимаг унших бичиг*”-т буй тод эхээс нь сугалан авч судлагааны хэрэглэгдэхүүн болгожээ¹⁶.

Энэхүү зарлигт хэн хүн боловч эв зөийг эрхимлэх; монгол ном бичиг сурах, сургах; ном бичиг сурахад залхуурч үл болох; шашин ном хийгээд сүм хийдийн баримтлалвал зохих хэм хэмжээ зэрэг тухайнхаа үеийн нийгэмийн тал талын харилцааг багтаасан боловч энэ удаа Монгол газар бурханы шашин эрчимтэй дэлгэрсэн тэр үеийн түүхэнд шууд холбогдох сүм хийд болон түүнд шавилан суух лам нарын тухай өдгөө бидний хувьд үлэмж сонирхол татахуйц заалтыг товч боловч танилцуулахыг зорилоо. Үүнд:

[р. 89]

... Ken kümün küböügen baqsidu öqci manji kekü bolxuna durān beyeni medeqgi. Arban dolōn nasun kürtülkiyini ödүү kürtülü nom үзүqgi. Öünēsü carū gecül gelenggiyin sakildu oruulxu bolxuna ecigenibo ali didarlaqci törölni tere durān zayisangdān küüneji olon axa döügiyin duruuni sur. Kerbe olon dundu kereqtei bolji axa döüni zöbšöl үлү ökönö otoqtuni oruulji yertemciyin kümü ke. Kerbe zöbšöl ökönö zayisangdān küüneji zöbdöl töüni noyondōn angqaryagi. Noyon zöb geküne xuruldu ayiladxuultuyai ✧

Ken xurultai xuburuqтай noyod xurliyinān labanar xuburyuudi j/aqla. Albatuyinan olon cōni kiri dünggēr j/aqgiyin tōtu gelenggöüd tōgōsu dutuxulai oromduni gecülmүүдēsü erdemdēn sayinēsuni ekelji bolyo. Edeni oromdu manjinariyin biliqtēgēsüni gecül bolyuul ✧

Ecigēsü yaqca küböün gecül geleng bü bolyo, yertüncүйin axa zangdu gulumtu үлү tasulxuyin tuldu...¹⁷

Олон нийтэд амар хялбар болгохын үүднээс энэ хэсэгийг одоогийн монгол хэлээр толилуулая.

...Хэн хүн хөвгүүнээ [лам] багшид өгч *манж*¹⁸ (=шавь) болгоно гэвэл өөрийнхөө дураар бол! Арвандолоон нас хүртэлээ ном үзэг! Үүнээс цааш гэцэл гэлэнгийн сахилтай болгоно гэвэл эцэг нь эсвэл ойр төрөл нь тэр хүсэлээ зайсандаа хэлж олон ах дүүгээсээ саналыг нь асуу! Хэрэв олондоо хэрэгтэй гэж ах дүү нь үл зөвшөөрөх бөгөөс отогт нь байлгаж ертөнцийн [хар^{III}] хүн болго! Хэрэв зөвшөөрөх бол зайсандаа хэлж зөвшөөрвөл ноёндоо айлтга. Ноён зөв гэвэл хуралд айлтгуултугай & Хуралтай хуврагатай ноёд хэн ч гэсэн хуралынхаа лам хуврагуудыг [мэдэж] ахла! Албатынхаа олон цөөний хэр дүнгээр байх тоот гэлэнгүүд тооноосоо дутавал оронд нь гэцэлүүдээс эрдэмдээ сайнаас нь эхлэн [сонгож гэлэн] болго! Эдний оронд нь

¹⁵ John R. Krueger, *New Materials on Oirat Law and History, Part One, the Jinjil Decrees*, Central Asiatic Journal, vol. 16 (3), 1972, pp. 194-205.

¹⁶ А. М. Позднеев, *Калмыцкая хрестоматия для чтения въ старшихъ классахъ калмыцкихъ народныхъ школь*, Санкт-Петербургъ, 1892, [172 стр.; второе издание, 1907, 195 стр.; третье издание, 1915, 196 стр.], стр. 89-92.

¹⁷ John R. Krueger, *New Materials on Oirat Law and History, Part One, the Jinjil Decrees*, Central Asiatic Journal, vol. 16 (3), 1972, [pp. 194-205], p. 197.

¹⁸ *Манж* гэдэг энэхүү үг ‘*банди, шавь*’ гэсэн утгатайг дараахи бүтээлээс үзмүү: John R. Krueger, *Materials for an Oirat-Mongolian to English citation Dictionary*, Part 1-3, Bloomington, Indiana, 1978, 1984. [816 pp.], p. 588.a.

манж нарын билигтэйгээс нь гэцэл болгуул ✧

Ертөнцийн аху занд (=ёсонд) [гал] голомт үл таслахын тул эцэгийн ганц хөвгүүн [байх юм бол] гэцэл гэлэн бүү болго! ...

Энэ хэсэгийг профессор Ж. Р. Крюгер англи болгосон нь:

If any man turns over his son to a teacher, and of it comes up about making him a novice, let him (the father) know his own wish. Let him (the son) learn to read at least as much as up to the age of seventeen. Further on, if it comes up about his taking the vows of *getsul* or *gelong*, his father or any close relative, after discussing their desires with their *zaisang*, are to learn the wishes of his many brothers. If he is needed by the community, and if the brothers do not give approval, make him join the clan and be a man of the world. If approval is granted, discuss it with the *zaisang*, and direct the attention of the prince to its approval. If the prince approves, let the *xural* be notified.

Any prince who has a *xural* and clergy, is to have disposition over the lamas and clergy of his *xural*. Dependent on the extent of his subjects as many or few, if the *gelong*s are below the number enumerated in the regulations, let him make (new *gelong*) in their place starting from the best in wisdom among the *getsuls*. In their place let him make (new) *getsuls* from those of wisdom amongst the novices. Do not make *gelong* or *getsul* out of the only son of a father, so as not to put an end to household under extant worldly customs.¹⁹

Энэхүү эшлэлээс үзвэл тэр үед нэг хошуу, нэг шавийн хүн амын тогтоосон тодорхой хувь нь чухамхүү эрдэм чадалаараа лам болдогоос биш хэн хүнгүй лам болоод, хэн болгоныг лам болгоод байдаггүй, өөрөөр хэлбэл төр засагийн зүгээс шашиныг зоргоор нь тавиагүй байсан байдал бэлээхэнээ харагдана. Үүнийг одоогийнхины ойлголтоор лам болох гэсэн хүний эрхийг хязгаарласан гэж муйхарлан ухах аргагүй. Энэ нь онгөн талаасаа хязгаарласан мэт харагдавч чухамдаа “хэмжээнээсээ хэтрэхээр аливаа юм болохоо больдог”, “хоол ч ихэдвэл хор болдог” хорвоогийн жамаар тухайн шашин болоод тухайн шашины лам хуврагын нэр хүндийг давхар хамгаалсан хэрэг. Үүний цаана төр, улс гэр, иргэн, цэрэг гэх зэрэг улс ороны хүн амзүйн нарийн бодолгын учир холбогдол бүрэнээ буй. Ийм учир холбогдол алс хэтээ гэсэн ямар ч төр улс, үндэстэн бүрт байдаг нийтлийг үзэгдэл.

Энэ мэтээр лам нарын тоог хязгаарласан зүйл Манж Чин Улсын “Хууль зүйлийн бичиг”-т бас буй. Гэхдээ монгол зарлиг хууль дахи дээрхи мэт заалт нь Монголчуудын төрийн бодолгоос үүдэлтэй тул түүнийг Манжийн бодолготой холбоотой гэж үзэхийн аргагүй. Энэ нь ямар ч улс ороны төрийн бодолгын төвд оршидог хүн амзүй болон батлан хамгаалах шаардалгатай холбоотой зүйл тул нийгэмийн түүхийн нийтлийгийн асуудал.

Манж Чин улсын үед засаг захиргаанаас нь хууль дүрэмийн дотор лам болсон хүмүүст өгдөг “гэрээс гарсаны тэмдэг бичиг” буюу “лагад гарахын тэмдэг бичиг” хэмээх тусхай барласан [119 x 64 см хэмжээ бүхий] муутуу хуудас-үнэмлэх байсан бөгөөд хуврага бологч болон аймаг хошууныхи нь нэр ус, лам болсон он, сар, өдөрийг нэмэн бөглөж зохих тамга тэмдэг дарсанаар хүчин төгөлдөр болдог байжээ. Ийм “тэмдэг”-тэй лам хүнийг цэрэгийн алба, гааль гувчуур зэргээс чөлөөлдөг, хэрэвээ “тэмдэг”-гүй хүн лам болсон байхулаа “хар лам” хэмээгдэж элдэв алба үздэг байсан бөлгөө. Энэхүү “тэмдэг бичиг”-ийн уламжлалын түүхийг үзвэл лав Тан улсын үед лав байсан ажээ. Чин улс эхин үедээ Монголд лам нарын тоог

¹⁹ John R. Krueger, *New Materials on Oirat Law and History, Part One, the Jinjil Decrees*, Central Asiatic Journal, vol. 16 (3), 1972, [pp. 194-205], p. 201.

хязгаартай байлгах сонирголоос үүдэн Гадаад Монголын төрийг засах Яамаар дамжуулан “*магад гарахын тэмдэг бичиг*”-ийг өгдөг байсан баримт бий²⁰.

Түүхэн баримт сэлтийг анхааралтай бодолцох бөгөөс Чин улсын эхин үед манж нарын зүгээс Монголд хандах хандалга нь сүүл үеийнхээ хятаджисан хаадынхаа бодолгоос ялгаатай, монголыг хан үндэстэнээс зааглах сонирхолтой байжээ гэж санагдуулахуйц зүйл ч буй. Энэ нь монголчуудын нүүдэл амьдралын хэвшинж болон хэл өөрсөдийнхитэй нь харьцангуй ойр, мөн монгол цэрэг эрсийн эрэлхэг дайчин чадвар, тэр чадварыг тоогоор үлэмж илүү өрсөлдөгчийн эсрэг ашиглана гэж тооцоноос биш манж нарын өгөөмөрийнхи огт бус. Үүнийг батлах нэг бус баримт Ази, Европод гарсан түүхэнд буй. Наад зах нь Сэнгэцэрэн хэмээх монгол нэрт жанжины нэр ус ч түүхэнээ хэдийнээ тэмдэглэгджээ. Тэгээд ч Манж Чин Улс нэгэн талаас Монголд нэвтрэх хятад хүний тоог харьцангуй хязгаарлаж, монгол эхнэр авах, газар хагалаж тариа тарихыг, нөгөө талаас монгол хүн хятад нэр авах, хятад ший жүжиг үзэх, хятад хэл сурахыг тус тус хориглосон баримт байдагийг судлагчид ажин тэмдэглэжээ²¹. Бас Манж Чин Улсын эзэн хаан өөрөө монгол засаг ноёд болон монгол хүнтэй хэл нэвтрэлцэх шаардалгатай хэмээн үзэж монгол хэл сурсан хийгээд түрүүн гарсан “*нэмэж тогтоосон*” манж хятад толийн дундуур монгол орчуулга нэмүүлсэн тухай мэдээг “*Хааны бичсэн Манж Монгол Хятад үсэг гурван зүйлийн аялгуу нийлсэн толь бичиг*”-т зориулан Тэнгэрийг тэдхэсэний 45-р (буюу аргын 1780) оны Хаврын сарын тэргүүн сарын арван нэгэнээ бичсэн оршилын монгол орчуулгаас олж харж болно. Үүнд:

...Нэмэж тогтоосон толь бичиг-тур гагц манжэ үг хятад үг буй. Ер монгол үг үгүй. Энэ бичиг-тур монгол үгийг хамтсар оруулсаны тулд нэмэж тогтоосон толь бичгээс өөр... (4а-5а)

...Би суурин-дур суусан анхны цагт олон гадаад монгол засагуудыгаа бүр мөргөөр ирмүй. Түүний үгийг ухаваас үл боломуй хэмээн, даруй монгол суран, хэдэн жил болсон үгүй-дур бүрэнээ чадав. Эдүгээ түүний гүн нарийн аялгууг гүйцэд мэдэмүй... (8б-9б) хэмээжүхүй.

Гэхдээ тэр үед ч манж нар монголын уламжлалт засаг захиргааны зохион байгуулалтыг хятадчилах, монгол үндэсний уугуул соёл боловсрол, сонгодог бүтээл туурвилыг хураах зэргээр Монголд таатай хандаж байгаагүйг хүлээн зөвшөөрөхгүй байхын аргагүй бөгөөд энэ талаархи баримт судлагаа ч гарсан бөлгөө²². (Энэ мэт манай түүхчидийн үзвэл зохилтой зарим холбогдох судлагааны товч танилцуулгыг 2-р хавсралтад толилуулав.)

Энэчилэн монгол дөрвөлжин хийгээд тод бичигийн дурасхалд зөвхөн шашин сургалтай холбоотой эл сэдэвийн хүрээнд мэргэжилийн хуульч хүний нүдээр харж гэмээ нь цааз эрхимжийн салбарт илүү олон, илүү сонин зүйл гарах нь мэдээж бөгөөд нарийвчилан судлах

²⁰ Миг-очир, *Мэргэдийг баясхагч цагаан түүх* (Алашаа хошууны баруун гүнгийн илэдхэд шаштир), Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 2008. [536 тал], 176-р зүүлт-тайлбар.

²¹ Ai T'ing, "Ch'ing-tai tui-yü meng-ku-ti chiao-yü cheng tsé" (Manchu educational policy towards Mongols), Hsi-pei yen-Chiu (North-west Monthly), N. 8, 1932, pp. 61-73; [See M. Chang Chih-yi, *A Bibliography of Books and Articles on Mongolia*, - Journal of the Royal Central Asian Society, London, Parts II and III, of Volume XXXVII., 1950, p. 23.]

²² Ling Shui-sheng, *Chung-kou pien-cheng-chih meng-ch'i chih-tu* (League and banner institution as China's frontier policy), "Pien-cheng kung-lun" (Frontier Affaire), Vol. II, Nos. 3-10 (Oct. 1943), pp. 1-12; Ai T'ing, *Ch'ing-tai tui-yü meng-ku-ti chiao-yü cheng tsé* (Manchu educational policy towards Mongols), Hsi-pei yen-Chiu (North-west Monthly), N. 8, 1932, pp. 61-73 [See M. Chang Chih-yi, *A Bibliography of Books and Articles on Mongolia*, - Journal of the Royal Central Asian Society, London, Parts II and III, of Volume XXXVII., 1950, pp. 10 & 23.]

эзэнээ хүлээж буй үлэмж сонирхолтой судлагдахуун болно гэдэг нь эргэлзээгүй.

Энэхүү өгүүлэлд монгол дөрвөлжин болон тод бичигийн дурасхалуудаас зөвхөн шашинтай холбоотой хэсэгийг товч төдий авч үзэв. Энэ жишигээр бичигийн дурасхалуудыг зөвхөн хэлний баримт гэж хязгаарлалгүй, агуулгын талаас нь авч үзэх бөгөөс түүх, соёл, нийгэмийн дотоод болон гадаад харилцаа, хууль цааз гэх зэрэг монголын судлалын тал талын салбарыг судлахад шинэ хэрэглэгдэхүүн болох төдийгүй түрүүчийн нийгэмийн үед бичсэн ном бүтээлийн баримтыг баяжуулахын хажуугаар буруу ташаа дүгнэлтийг нь ч залруулах боломжийг давхар олгох болно.


3. Монголчууд яагаад Бүддийн шашиныг сонгох болов?

Нэгэнт монгол нутагт гурвантаа дэлгэрсэн гэж үздэг бурханы шашины сүүлийн хоёр удаад нь шууд хамаарах дээр дурадсан хоёр зүйлийн бичигээрхи бодот баримт болон бас бус өөр хэрэглэгдэхүүн, судлагаа тэргүүтэнийг харгалзан үзэх бөгөөс дэлхий гол томоохон шашинтай сайтар танилцсан монголчууд яагаад Бүддийн шашиныг сонгов гэдэг асуултанд бүрэн бус боловч зарим талын хариу олдоно гэж бодож байна.

Бурхан багшийн номд *намайг шууд дага!* гэлгүй *миний сургаалтай танилцаад зөв гэж бодох бөгөөс шүтэгтүн* гэж чөлөө эрх олгодог, шүтэж гэмээ нь гурван цагийн туршид бие, хэл, сэтгэл гураваа чандлагтун, бурхан ганц байдаггүй тул чандлан хичээх бөгөөс та ч өөрөө бурханы хутагийг олж чадна хэмээн номлодог нь монгол хүний *эзэн хичээвэл заяа хичээнэ* гэдэг уугуул гүн ухаантай таардаг учир ертөнцөд ганц л Эзэн байдаг, намайг заавал дага! хэмээн номлодог бусад шашинаас уг шашиныг сонгоход илүү ойр дөхөм санагдсан нь эргэлзээгүй буй заа. Бас бурхан багшийн номд гурван цагийн турш үргэлжид бие, хэл, сэтгэлийн нүгэлгүй байх, дайсан хэмээн санагдавч эх болсон зургаан зүйл хамаг амьтанд адил тэгш өгөөмөр сэтгэл гаргах, эдийн бус сэтгэлийн амгаланг юу юунаас илүү эрхэмлэхийг сургадаг нь, өнөөдөрөөс ирээдүй эхлэдэг хэмээн өчигдөрийнхөө нүгэлийг сүмд очиж цайруулаад сэтгэлээ амраадаг, өнгөрсөнийг огоорч, үргэлж ирдэг өнөөдөр, үргэлжилэж ирдэг маргааш хэмээх ирээдүйг чухалчилаад эдийн шунал хүлээсэнд автах, дайсан гэж үзэх бөгөөс *"нүдний төлөө нүд, шүдний төлөө шүд"* хэмээн хонзогнож хэнийг ч хөнөөхөд бэлэн зэлэн байдаг бусад шашинтай адилгүйг таньсантай холбоотой. Сайтар эргэцүүлэх бөгөөс буян нүгэл гэдэг ойлголт шашин дэлгэрэхээс өмнө ч монгол түмэнд нарийн тогтолцоотой байж, сайн саар бүх зүйл өнгөрсөн, одоо, ирээдүй гурван цагийн хэлхээнд хамааралтай гэж итгэдэг, *сайн хүний үр, сүүт гүүний унага* гэдэгчилэн сайнаас сайн, муугаас муу гардаг хэмээн үздэг үзэл нь ч бурханы шашины түүн-лүгээ адил сургаали монголчуудын дунд ээнэгшин дэлгэрэхэд нөлөөлөхгүй байхын аргагүй ойр үзэл байсантай холбоотой буй заа. Гэвч Монгол төрийн бодолгод бурханы шашин төдий л нөлөөтэй бус байсан ч, дэлхий дахинаа үлэмж нөлөөтэй болсон Их Монгол Улсын үеэс улируулан үзэх бөгөөс бусад шашиныг ч, бусад шашинтаныг ч, суурин болон нүүдэл аж төрөлтөнийг ч онцгой зааглан ялгаж байгаагүйг дөрвөлжин бичигээрхи бүх зарлигууд нутлах бөгөөд энэ байдалыг судлагчид ч хүлээн зөвшөөрсөөр бөлгөө²³

²³ Thomas T. Allsen, *A Note on Mongol Imperial Ideology*, - The Early Mongols: Language, Culture and History, Studies in honor of Igor de Rachewiltz on the Occasion of his 80th Birthday, Edited by Volker Rybatzki, Alessandra Pozzi, Peter W. Geier and John R. Krueger, Indiana University Uralic and Altaic Series, Denis Sinor editor, Vol. 173, Bloomington, Indiana, 2009 [217 pp.], pp.1-8.

1-р хавсралт:



[中国少林寺 (Zhongguo Shaolin si), Volume 1-3, (Zhonghua Shuju), ISBN 710 10 38999, 2005 年, See Vol. 2, pp. 84-85.]

2-р хавсралт:

Манж Чин Улсаас Монгол руу хандсан бодолгын талаар XX зууны эхээр гарсан боловч манай судлагчидын бүтээлд төдий л байр суурь эзлээгүй боловч үзвэл зохилтой, сонирхолтой баримт сэлт бүхий дөрвөн өгүүлэлийн танилцуулгыг дам толилуулсу. Үүнийг монголынхоо түүхчидэд танилцуулахаар монголч эрдэмтэн О. Латтимор (O. Lattimore)-ын удирдалгаар хийж 1950 онд Лондон хотноо *Journal of the Royal Central Asian Society* сэтгүүлийн XXXVII ботийн II-III дэвтэрт нийтлэгдсэн М. Chang Chih-yi гэдэг хүний *A Bibliography of Books and Articles on Mongolia* [pp. 1-49] гэдэг номзүйн бүтээлээс сэдэвтээ хамааруулан цоолдож авсан болно.

1. Боловсролын талаархи бодолгод холбогдох нь:

1. 1. 3 Ai T'ing, "Ch'ing-tai tui-yü meng-ku-ti chiao-yü cheng tsé" (Manchu educational policy towards Mongols), - Hsi-pei yen-Chiu (North-west Monthly), N. 8, 1932, pp. 61-73.

Contents:

1. Manchu educational policy towards Mongols:
 - (a) confiscation of Mongol classics,
 - (b) segregation of Mongols from the Chinese.
2. Schools set up by the Manchus for Mongols and Tibetans

Comments:

A short presentation of the Manchu educational policies towards the Mongols. Confiscation of Mongol classics was carried out in 1743. Segregation of Mongols from Chinese took the form of prohibiting Mongols to learn Chinese, to adopt Chinese names, to see Chinese operas.

The two schools established by the Manchus for Mongols aimed at training translators. The Tibetan language was taught in those schools. [p. 1]

[See M. Chang Chih-yi, *A Bibliography of Books and Articles on Mongolia*, - *Journal of the Royal Central Asian Society*, London, Parts II and III, of Volume XXXVII., 1950, p. 23.]

2. Засаг захиргааны талаархи бодолгод холбогдох нь:

2. 1. 3 Kuan Chou-hua, *Meng-ku meng-chi chih-tu shu-liao* (Survey of Mongol League and Banner Organization), - "Hsin-ya-his-ya" (New Asia), Vol. V, No. 6 (June, 1933), pp. 53-7.

Comments:

A sketchy appraisal of Mongol banner and League. Emphasis on league organizations, whose inefficiency, according to Kuan, was the result of lack of express provisions for strengthening the mechanism of the league, as can be seen from the statutes of the Board of Frontier Affairs. For instance, there was practically no permanent staff for the league administration.

[See M. Chang Chih-yi, *A Bibliography of Books and Articles on Mongolia*, - Journal of the Royal Central Asian Society, London, Parts II and III, of Volume XXXVII., 1950, pp. 8-9]

2. 2. 3 Ling Shui-sheng, *Chung-kou pien-cheng-chih meng-ch'i chih-tu* (League and banner institution as China's frontier policy), - "Pien-cheng kung-lun" (Frontier Affaire), Vol. II, Nos. 3-10 (Oct. 1943), pp. 1-12,

Contents:

1. Origin of banner organization.
2. Functioning of banners.
3. Tribes, leagues and banners.
4. Functioning of leagues.
5. "Aimaks" under the direct control of the central government.
6. Banner organization of Moslems.
7. Basic difference between "Eight Banners" and Mongol banners.
8. Present situation of leagues and banners. -

Comments:

... In his opinion, the league and banner organization represented one of the four major frontier institution in the past. The other three were: (1) the policy of changing the authority over tribes-people from native chief-tains to regular Chinese officials, as practiced in the south-west with regard to the Miao, Yao and so forth; (2) the theocratic institution; and (3) the tribal organization. It was designed to split each big Mongol tribe into several artificial banners – a policy of "divide and rule"

[See M. Chang Chih-yi, *A Bibliography of Books and Articles on Mongolia*, - Journal of the Royal Central Asian Society, London, Parts II and III, of Volume XXXVII., 1950, p. 10]

2. 3. 3 To Chin, Wen K'ang and others, *Ch'ingting Li-fan Yuan tse-li* (Official Regulation Governing the Board of Frontier Affairs), compiled in 1911, enlarged in 1825, revised in 1890-91, 64 chüan.

Comments:

This voluminous collection of statutes of the Manchu Court relating to Mongol and Tibetan affairs had been until recently the basic civil and criminal code in Mongolia. A Russian translation by Stefan Lipotzov, *Ulozhenie Kitaiskoi paloty Vneshnykh snoshenii*, 2 vols., St. Peterburg, 1828, is available, although many new revisions made during the years 1833-41 are still left untranslated.

[See M. Chang Chih-yi, *A Bibliography of Books and Articles on Mongolia*, - Journal of the Royal Central Asian Society, London, Parts II and III, of Volume XXXVII., 1950, pp. 12-14]